



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А80

Улаанбаатар хот

Гадаад арга хэмжээнд оролцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2 дахь заалтыг үндэслэн
ТУШААХ нь:

1. Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн Ерөнхий захирал Н.Эрдэнэбаярыг Бүгд Найрамдах Турк улсын Анталья хотод зохион байгуулагдах Азийн цус сэлбэлт судлалын нийгэмлэгийн 12 дугаар хуралд оролцох, илтгэл тавьж хэлэлцүүлэх зорилгоор 2016 оны 04 дүгээр сарын 04-06-ны өдрүүдэд албан томилолтоор ажиллахыг зөвшөөрсүгэй.

2. Арга хэмжээнд оролцох удирдамжийг хавсралтаар баталж, ажлын тайланг ирсэн өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан танилцуулахыг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн Ерөнхий захирал /Н.Эрдэнэбаяр/-д үүрэг болгосугай.

3. Дээрх хугацаанд төвийн захирлын албан үүргийг тус төвийн Чанар, цусны сонор сэрэмжийн албаны дарга Т.Алимаагаар түр орлон гүйцэтгүүлсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Эрдэнэчимэг)-т үүрэг болгосугай.


САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

030264

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 03 сарын 15 өдрийн
А80 дугаар тушаалын хавсралт



АЗИЙН ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН НИЙГЭМЛЭГИЙН
12 ДУГААР ХУРАЛД ОРОЛЦОХ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Бүгд Найрамдах Турк улсын Анталья хотод зохион байгуулагдах Азийн цус сэлбэлт судлалын нийгэмлэгийн 12 дугаар хуралд оролцох, илтгэл тавьж хэлэлцүүлэх.

Хоёр.Хугацаа

2016 оны 04 дүгээр сарын 04-06-нд.

Гурав. Арга хэмжээ болох газар

Бүгд Найрамдах Турк улсын Анталья хот.

Дөрөв. Ажиллах чиглэл

- Олон улсын хуралд цусны алба болон эрдэм шинжилгээний чиглэлээр илтгэл тавьж, хэлэлцүүлэх
- Цусны төвийн олон улсын магадлан итгэмжлэхийн бэлтгэл ажлыг хангах чиглэлээр уулзалт хийх